



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ НАМЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 13-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 12 дугаар сарын 13-ны өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	2
<hr/>	
<i>1.Горимын санал</i>	2

Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы Хянан шалгах түр хороо /Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах/-ны 12 дугаар сарын 13-ны өдөр /Лхагва гараг/-ийн нээлттэй хуралдааны товч тэмдэглэл

Хянан шалгах түр хорооны дарга Ж.Чинбүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 7 гишүүнээс 4 гишүүн хүрэлцэн ирж, 57.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 45 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Батлут.

Түр хорооны дарга Ж.Чинбүрэн Хянан шалгах түр хорооны хянан шалгагч томилох учраас хуралдааныг хаалттай явуулах горимын санал гаргав.

Ж.Чинбүрэн: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 1

Бүгд: 5

80.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул 10 цаг 50 минутад хуралдааныг хаалттай горимд шилжүүлэв.

Нээлттэй хуралдаан 05 минут үргэлжилж, 7 гишүүнээс 5 гишүүн хүрэлцэн ирж, 71.4 хувийн ирцтэйгээр 10 цаг 50 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХЯНАН ШАЛГАХ ТҮР
ХОРООНЫ ДАРГА

Ж.ЧИНБҮРЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 12 дугаар сарын 13-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
10 цаг 45 минут.

ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Чинбүрэн: Эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая. Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул түр хорооны 23 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Хуралдааны ирцийг танилцуулъя.

Жаргалмаа гишүүн ирсэн байна. Бейсен гишүүн ирсэн байна. Сандаг-Очир гишүүн ирсэн байна. Миний бие байна. Ингээд ирц 57.1 хувьтай байна.

Өнөөдрийн хуралдаанаар дараах асуудлыг хэлэлцэнэ.

1. Түр хорооны хянан шалгагч 1, шинжээч нарыг томилох асуудлыг та бүхэнд бас нэмж томилох асуудлыг танилцуулах гэж байна.

2-т, эмийн чанарын хяналтын лаборатори зах зээлээс эм авч шинжлүүлэх тухай Хянан шалгах түр хорооны тогтоолыг батлах шаардлагатай байна.

Туваан гишүүн хүрэлцэн ирсэн байна. Ингээд ирц 71.4 хувьтай байна.

3-т, Хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах, нотлох баримтыг шинжлэх, судлах тов тогтоох талаар гишүүдээс санал сонсох гэсэн ийм 3 асуудлыг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудлын талаар өөр саналтай гишүүд байна уу? Тэгвэл хэлэлцэх асуудалдаа оръё.

Өнөөдөр хурлаар Хянан шалгах түр хорооны хянан шалгагч, шинжээч нарыг томилох зэрэг дотоод асуудлыг хэлэлцэх учраас хуралдааныг хаалттай горимоор явуулах саналыг гаргаж байна.

Тэгээд энэ хаалттай горимоор явуулах саналыг дэмжих, шилжүүлэх горимын саналаар санал хураалт явуулъя. Хаалттай горимоор явуулахыг дэмжиж байгаа гишүүдийн санал авъя.

Санал хураалт. Дотоод асуудал хэлэлцэх учраас.

Гишүүдийн 80 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Хуралдааныг хаалттай горимд шилжүүлнэ.

Ингээд хаалттай горимд шилжүүлбэ.

10.50 цаг

ДУУНЫ
ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

БИЧЛЭГЭЭС

БУУЛГАЖ,

П.МЯДАГМАА